



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/726

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит

сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (4 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**БУЛГАН ТАЛ**

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

Иргэдийнхээ эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэхэд энэхүү мөрийн хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

- ✓ Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- ✓ Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих “Эрүүл чийрэг хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Хүчирхийлэлгүй Эрдэнэбулган хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**ХОЁР: ХҮҮХЭД**


- ✓ Хүүхдийг цахим халдлагаас сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- ✓ Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дэмжинэ.
- ✓ Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хөтөлбөр болон, төсөл хэрэгжүүлнэ.
- ✓ Дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.

**ГУРАВ: ЗАЛУУЧУУД**

- ✓ Залуучуудын хөгжлийн Community center байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
- ✓ Залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор Бялдаржуулах төвийг 100% ашиглалтад оруулна.
- ✓ Нутаг орноосоо алс суралцаж байгаа болон ажиллаж байгаа залуусын бүтээлч санаачилгыг ажил хэрэг болгох бүхий л боломжийг нээнэ.

**ДӨРӨВ: ОЮУТАН**

- ✓ Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж байгаа оюутныг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- ✓ Гадаад улсын их дээд сургуульд элсэн суралцах оюутны тоог нэмэгдүүлэх бүхий л боломжийг эрэлхийлж ажиллана
- ✓ ДАНИ улсын их дээд сургуульд оюутан сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.



*[Handwritten signature]*

0000000001

### **ТАВ: АХМАДУУД**

- ✓ Ахмад настанд зориулсан сэргээн засах эмчилгээ, сувилгааны төв байгуулна.
- ✓ Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар, орон нутагт дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга гарган ажиллана.
- ✓ Ахмадын сургалтын төв байгуулж, дахин ур чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Ахмадыг төвийг шинээр ангилалтад оруулна.

### **ЗУРГАА: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС**

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тогтмол орлого олох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг дэмжих бодлого барьж ажиллана.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засах төвийг ажиллуулна.
- ✓ Тэгш хамран сургах хөтөлбөрийг чанаржуулна.

### **ДОЛОО: ЭРҮҮЛ МЭНД**

- ✓ Эмч, эмнэлгийн ажилтнуудыг чадавхжуулах, нарийн мэргэшүүлэх чиглэлээр бодлого барьж ажиллана.
- ✓ Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг их засварт оруулж, сэргээн засах, урьдчилан сэргийлэх төв болгон ажиллуулна
- ✓ КОВИД-ын дараах эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг цогц аргаар шийдвэрлэх чиглэлээр бодлого барьж ажиллана.
- ✓ Уламжлалт эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх иргэдийг хөхүүлэн дэмжинэ.
- ✓ Хуурамч, чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулан, транс тос, сахар, далд давсны хэмжээг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж ажиллана.
- ✓ Хүн амын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог тогтмолжуулж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

### **НАЙМ: БОЛОВСРОЛ**

- ✓ Сургалтын орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулна.
- ✓ Шинэ дотуур байр барих суудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлнэ.
- ✓ Бага сургуулийн хичээлийн байрын урсгал засварын ажлыг шийдвэрлэнэ.
- ✓ Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад орон нутгийн зүгээс, өөрийн эрх хэмжээнд бүхий л боломжийг ашиглана.
- ✓ Хүүхдийн хөгжлийг дэмжсэн, орон нутгийн нөөц боломжийг ашигласан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Хүүхэд хамгааллын ажлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулна.



0000000002

- ✓ Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, насан туршийн суралцахуйн багш, боловсролын үйлчилгээнд оролцогчдын хандлага, чадварыг нэмэгдүүлэх бүх санаачилгыг дэмжинэ.
- ✓ Боловсролын удирдлагын манлайлалд дэмжлэг үзүүлнэ.
- ✓ Боловсролын үйлчилгээнд оролцогч хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

#### **ЕС: БИЗНЕС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**


- ✓ Баялаг бүтээгч иргэдийн үйл ажиллагааг орон нутгийн эрх хэмжээнд дэмжиж, тэдний орлогыг нэмэгдүүлэх талаар хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Ажлын байр нэмэгдүүлж буй бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.
- ✓ Шинэ үйлдвэрлэл, инновацыг дэмжинэ.
- ✓ Эрдэнэбулган-брэнд бүтээгдэхүүний төвлөрсөн худалдааг зохион байгуулах санаачилга гарган ажиллана.

#### **АРАВ: МАЛ АЖ АХУЙ**

- ✓ Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- ✓ Мах, сүү, шувуу, зөгийний эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуй нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.
- ✓ Малыг эрүүлжүүлэх, чанаржуулах талаар хөтөлбөр боловсруулж ажиллана.

#### **АРВАН НЭГ: БАРИЛГА, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ**

- ✓ Орон сууц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Чичингийн 15 км замыг үе шаттайгаар хатуу хучилттай болгох зорилт тавьж, УИХ, ЗГ, гадаадын тусламж болон бусад холбогдох газруудад санал хүсэлт тавьж ажиллана
- ✓ Сумын төвийн гол замуудыг хатуу хучилттай болгоно.
- ✓ Дулааны шугамыг 4 чиглэлд, босоо тэнхлэгийн дагуу хийх зорилт тавьж УИХ, ЗГ, гадаадын тусламж болон бусад холбогдох газруудад санал хүсэлт тавьж ажиллана.
- ✓ 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын хөрөнгийг улсын төсөвт суулгах саналыг УИХ, ЗГ-т тавьж шийдвэрлүүлнэ.
- ✓ Цаг уурын мэдээ мэдээллийг түргэн шуурхай дамжуулах платформ бий болгоно.
- ✓ Уртын давааны зам засварыг хийнэ.
- ✓ Эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлж 35кв болгох талаар УИХ, ЗГ, гадаадын тусламж болон бусад холбогдох газруудад санал хүсэлт тавьж ажиллана.
- ✓ Бяслагийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.
- ✓ Төрийн үйлчилгээний цахим системийг бүх багт нэвтрүүлнэ.



*[Handwritten signature]*

0000000003


- ✓ 1-р багийн соёлын төвийг өргөтгөнө.
- ✓ 3-р бгт 4G сүлжээг нэвтрүүлнэ.
- ✓ Аялал жуулчлалын мэдээллийн төвийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- ✓ Хүүхэд, залуучуудын соёл амралтын хүрээлэнг бий болгоно.
- ✓ Бүх багуудын зорчих гол замуудыг тухай бүр засварлана.
- ✓ Үүрийн голын төмөр бетонон гүүрний ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагуудаар боловсруулна.
- ✓ 2-р баг, Чичингийн үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээг ашиглалтад оруулна.

#### **АРВАН ХОЁР: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

- ✓ Төрийн үйлчилгээг мэдлэгтэй, хариуцлагатай, сэтгэлтэй, ил тод хүргэж ажиллана.
- ✓ Төрийн албан хаагчдын чадвар, хандлагыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллана.

#### **АРВАН ГУРАВ: ХҮН АМЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

- ✓ Онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллана.
- ✓ Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, суваг шуудуу барих ажлыг тасралтгүй хийнэ.
- ✓ Ахуйн болон объектын гал түймрээс сэргийлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээг хийлгэж ажиллана.
- ✓ Онцгой байдлын үед ажиллах албан хаагчдыг чадавхжуулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулна.
- ✓ Хилчдийн ар гэр болон ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллана.



0000000004